“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.02.21 № СЭ-112-12/640

танай ______________-ны № ______________-т

“ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ТҮҮХИЙ ЭД, ШҮҮ” НИЙЛҮҮЛЭХИЙГ СОНИРХОГЧДОД

Хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Эмульсийн тэсрэх бодисын түүхий эд, шүү” нийлүүлэгчийг сонгох шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102053 дугаартай тендерт оролцогчоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр (www.tender.gov.mn) дамжуулан гаргасан тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА С.ЭНХМАНДАХ

61240700З783

**–ЭҮТӨҮГ/20240102053 ДУГААРТАЙ ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ТҮҮХИЙ ЭД, ШҮҮ НИЙЛҮҮЛЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН ТОДРУУЛГЫН ХАРИУ**

2024-02-19

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар 26 дугаар зүйлийн 26.1-т "Өмнөх татварын жилийн албан татвар ногдуулах орлого нь 6 тэрбум төгрөг ба түүнээс дээш бол уг албан татвар төлөгч тухайн татварын жилийн улирлын татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн татварын тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ" гэж заасан. Татварын ерөнхий газар жилийн эцсийн татварын тайлан гаргах хугацааг сунгасан. Түүнчлэн аж ахуй нэгжүүд санхүүгийн тайланг Төрийн сангийн цахим системээр баталгаажуулж амжаагүйгээс болж тендер шалгаруулалт амжилтгүй болох, улмаар тэсрэх бодисын үйлдвэрийн түүхий эд, шүүний нөөц дуусах, үйлдвэр зогсох эрсдэлтэй байдаг.

Тиймээс "Эмульсийн тэсрэх бодисын түүхий эд, шүү" нийлүүлэх, ЭҮТӨҮГ/20240102053 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт 2021, 2022 оны санхүүгийн тайлан, туршлагын талаар шалгуур тавьсан.

Мөн. Ямар нэг компанийн хүсэлтээр тэдгээрийн эрх ашигт нийцүүлэн тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах боломжгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Тендерийн үнэлгээний хорооны дарга Л.Баярбат

Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Т.Ууганбаяр